



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/42/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Аудитор: М.Бямбадорж

Утас: 99031981 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com


Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайшанд сум, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ИХХЭТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ С.ХҮРЭЛБААТАР ТАНАА
<u>2019-02-23</u> № <u>1-6/123</u>	
Танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<p>9825555</p> 	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал С.Хүрэлбаатар-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 01-наас 2018 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг аудит” ХХК -д 2018 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 1515 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсролын тухай хуулиа Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх,

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

байхгүй

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 1 хувиар сонгов.

Нийт орлого -г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Тус байгууллага нь төсвийн санхүүжилтээр төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг учраас төрөөс олгож байгаа санхүүжилтийн орлогыг суурь үзүүлэлт болгон сонгон авлаа - холбоотой юм.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт орлого* 7,713.08 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,713.08 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт орлогын 1 хувиас хэтэрсэн алдаа, зөрчил нь санхүүгийн тайланд нөлөөлөхүйц алдаа болох юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	24,086.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	24,086.80	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БСШУСЯ-аас баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийн мөрдөлт

Багш нарын үр дүнгийн урамшууллын үнэлгээ, тооцоолол, Хөрөнгө бэлтгэх, түүнийг бүртгэх, тайлагнах үйл ажиллагаа

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 743039,3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 742791,7 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь эд хогшил зардлын данс 230,0 мянган төгрөгийн хэмнэлт гарсан нь төсвийн хэмнэлтэд голлон шалтгаалжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө тавигдаагүй

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Тус сургуульд 334 суралцагч суралцаж байгаа бөгөөд нийт 37 ажилтан ажиллаж байна. Ажиллагсдын орон тоо 2-оор илүүдэлтэй ажиллаж байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна БСШУССайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаал тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа БСШУССайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалыг мөрдөн ажиллаж ажиллагсдын орон тоо бүтцийг мөрдөн ажиллах шаардлагатай.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Э.Сүглэгмаа

Эрсдэл

1. Цалингийн зардал хэтэрч төсвийн үр ашиггүй зардал бий болох.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн тодруулга болон тооцоо нийлсэн актыг тулган шалгахад Татварын албанаас 115.7 мянган төгрөг, "Чандмань илч" ХХК-д 7000.2 мянган төгрөг, "Хос гэгээн наран" ХХК-д 230.5 мянган төгрөг, НДХ-д 287.5 мянган төгрөгийн өглөгийг тус тус тайлагнасан байна.

Энэ нь эрх ба үүрэг, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Төсвийн хуулийн мөрдөн ажиллаж авлага өглөг үүсгэхгүйн тулд төсвийн хуваарилалт, төлөвлөлтийг оновчтой болгох, үүссэн өр төлбөрийг шийдвэрлэхийн тулд холбогдох тооцооллыг бодитой хийх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Э.Сүглэгмаа

Эрсдэл

Төсвийг үр ашиггүй, бодит тооцоололгүй зарцуулж төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Цалингийн хүснэгт болон төлбөрийн хүсэлт, харилцах дансны хуулгаар 6195.0 мянган төгрөгийг хуримтлалд суутган авсан байгаа бөгөөд 1-11 дүгээр сард ажилтан тус бүрээс 15.0 мянган төгрөг, 12 дугаар сард 30.0 мянган төгрөг суутган авсан

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1.Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно: 63.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан, 63.1.2.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1.Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно: 63.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан, 63.1.2.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж шүүхийн шийдвэр болон холбогдох эрх зүйн актгүйгээр ажиллагсдын цалингаас суутгал суутгахгүй байх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Э.Сүглэгмаа

Эрсдэл

1. Ажиллагсдын цалингаас суутгах суутгал нэмэгдэж гарт олгох цалин дутуу олгогдох.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09/10 тоот тогтоолын дагуу 14 нэр төрлийн 7270.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан. Энэ нь Төрийн өмчийн хорооны холбогдох дүрэм, журамтай зөрчилдөж байна.

Зөвлөмж

Улсын төсвийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг актлахдаа Төрийн өмчийн хорооны зөвшөөрлөөр актлах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Иххэт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Хүрэлбаатар, нягтлан бодогч Э.Сүглэгмаа

Эрсдэл

1. Төсвийн хөрөнгө үнэгүйдэх, ашиглалт сулрах.

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ц.ЛҮНДЭГМАА	Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	М.БЯМБАДОРЖ	Огноо:
---------	-------------	--------

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТАЛСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>72,439,071.82</u>	<u>84,842,785.81</u>
33	АВЛАГА	6,489,024.00	115,680.00
335	Бусад авлага	6,489,024.00	115,680.00
3351	Байгууллагаас авах авлага	6,489,024.00	115,680.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65,950,047.82	84,727,105.81
351	Түүхий эд материал	54,606.00	204,300.00
35130	Эм боох материал	54,606.00	204,300.00
354	Хангамжийн материал	65,325,441.82	83,952,805.81
35410	Бичиг хэргийн материал	2,412,676.00	2,298,800.00
35420	Аж ахуйн материал	45,442,719.82	62,101,099.81
35460	Хүнсний материал	2,004,246.00	4,087,106.00
35470	Бусад хангамжийн материал	15,465,800.00	15,465,800.00
35600	Мал амьтад	570,000.00	570,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>932,346,064.32</u>	<u>945,751,988.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	932,346,064.32	945,751,988.53
392	Биет хөрөнгө	932,346,064.32	908,225,988.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,522,884,365.00	767,540,106.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-750,381,092.74	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	210,156,838.51	185,666,505.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-114,625,753.63	-102,114,633.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,380,381.50	83,930,035.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,804,794.68	-65,369,302.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,000,000.00	31,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,549,999.82	-10,449,999.78
39217	Ном	19,286,120.18	18,023,278.28
393	Биет бус хөрөнгө	00.00	37,526,000.00
39301	Програм хангамж	1,000,000.00	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,000,000.00	-1,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	37,526,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,004,785,136.14</u>	<u>1,030,594,774.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14.00</u>	<u>7,518,186.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14.00	7,518,186.00
413	Өглөг	14.00	7,518,186.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	287,458.00
4136	Бусад өглөг	14.00	7,230,728.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14.00	7,230,728.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,004,785,122.14</u>	<u>1,023,076,588.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,004,785,122.14	1,023,076,588.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492,553,516.49	530,079,516.49
51101	Өмч: - төрийн	492,553,516.49	530,079,516.49
512	Хуримтлагдсан үр дүн	41,085,951.51	140,539,324.11
51210	Өмнөх үеийн үр дүн	41,085,951.51	41,327,951.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	99,211,372.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	471,145,654.14	352,457,747.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,004,785,136.14</u>	<u>1,030,594,774.34</u>

4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	470,868,730.00	771,307,843.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,184,830.00	27,008,143.81
120	Нийтлэг татварын бус орлого	21,184,830.00	27,008,143.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,184,830.00	27,008,143.81
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,184,830.00	27,008,143.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,683,900.00	744,299,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	743,039,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	743,039,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,252,000.00	1,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,252,000.00	1,260,000.00
1330	Төсвийн захирагчдаас	443,431,900.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,431,900.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	465,855,664.10	646,641,344.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,855,664.10	646,641,344.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,296,064.10	631,262,530.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,954,835.96	326,193,438.00
210101	Үндсэн цалин	224,644,883.96	307,983,766.00
210102	Нэмэгдэл	11,214,952.00	423,088.00
210104	Урамшуулал	95,000.00	17,786,584.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,960,201.00	39,263,454.00
210201	Тэтгэврийн даатгал	16,888,474.00	26,154,005.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,205,451.00	3,022,671.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,984,234.00	2,504,103.00
210204	Ажилгүйдлийн даатгал	443,822.00	608,688.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,438,220.00	6,973,987.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,254,380.00	149,396,922.00
210301	Гэрэл, цахилгаан	3,056,296.00	6,169,155.00
210302	Түлш, халаалт	89,360,008.00	135,685,576.00
210303	Цэвэр, бохир ус	2,838,076.00	7,542,191.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,305,440.00	12,746,904.82
210401	Бичиг хэрэг	1,045,940.00	2,214,176.00
210402	Тээвэр, шатахуун	2,157,740.00	3,255,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	316,500.00	721,750.00
210404	Ном, хэвлэл	154,060.00	181,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,571,200.00	2,640,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	3,673,948.82
2105	Нормативт зардал	21,844,077.00	33,006,251.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,922.00	263,806.00
210502	Хоол, хүнс	21,730,155.00	32,742,445.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,180,300.00
210604	Урсгал засвар	-	2,180,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,212,000.00	702,000.00
210702	Дотоод албан томилолт	1,212,000.00	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	403,000.00	941,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	403,000.00	941,426.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,362,130.14	66,831,834.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,000.00	999,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	951,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,108,130.14	64,881,334.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,559,600.00	15,378,814.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,559,600.00	15,130,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,405,000.00	1,953,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,911,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,242,800.00	13,177,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	248,014.00

Иххэт сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	248,014.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,013,065.90	124,666,499.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	25,455,127.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,080,226.64
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	20,374,900.42
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(25,455,127.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,013,065.90	99,211,372.60

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	367,730,300.00	744,299,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	367,730,300.00	744,299,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	743,039,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	743,039,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,212,000.00	1,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,212,000.00	1,260,000.00
1330	Төсвийн захирагчдаас	366,518,300.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366,518,300.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	282,161,528.00	744,299,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,161,528.00	744,299,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,738,728.00	714,158,886.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,641,681.00	326,193,434.00
210101	Үндсэн цалин	122,584,736.00	229,167,818.00
210102	Нэмэгдэл	28,883,797.00	68,745,565.00
210104	Урамшуулал	17,173,148.00	28,280,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,860,897.00	38,976,000.00
210201	Тэтгэврийн даатгал	13,601,901.00	25,983,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	141,387.00	3,248,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	209,800.00	2,598,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	113,109.00	649,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,794,700.00	6,496,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,274,925.00	136,023,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,503,042.00	6,169,155.00
210302	Түлш, халаалт	67,984,056.00	122,006,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,787,827.00	7,847,745.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,108,720.00	5,652,384.00
210401	Бичиг хэрэг	339,300.00	550,000.00
210402	Тээвэр, шатахуун	547,710.00	2,732,994.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	427,760.00	740,000.00
210404	Ном, хэвлэл	85,200.00	579,990.00

Иххэт сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	249,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	648,750.00	799,900.00
2105	Нормативт зардал	9,520,355.00	21,787,305.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,150.00	224,000.00
210502	Хоол, хүнс	9,238,305.00	20,063,305.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	202,900.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	656,800.00	175,704,837.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	656,800.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	174,204,837.00
2107	Томилолт, зочны зардал	1,212,000.00	702,000.00
210702	Дотоод албан томилолт	1,212,000.00	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	469,200.00	859,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,200.00	859,626.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,994,150.00	8,259,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,000.00	2,499,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,825,150.00	5,759,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,422,800.00	30,140,814.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,422,800.00	29,892,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,422,800.00	16,715,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,177,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	248,014.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	248,014.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	85,568,772.00	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,643,180.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,643,180.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	11,643,180.00	-
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	11,643,180.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,643,180.00)	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	73,925,592.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	73,925,592.00	-

Иххэт сумын ЕБС-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,553,516.4 ₉	471,145,654.14	(104,974,784.17)	858,724,386.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,553,516.4₉	471,145,654.14	(104,974,784.17)	858,724,386.46
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	37,711,642.30	37,711,642.30
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,553,516.4₉	471,145,654.14	41,085,951.51	1,004,785,122.1 ₄
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	492,553,516.4₉	471,145,654.14	41,085,951.51	1,004,785,122.1 ₄
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	242,000.00	242,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	492,553,516.4₉	471,145,654.14	41,327,951.51	1,005,027,122.1 ₄
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(118,687,906.40)	-	(118,687,906.40)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	37,526,000.00	-	99,211,372.60	136,737,372.60
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,079,516.4₉	352,457,747.74	140,539,324.11	1,023,076,588.3 ₄

4.5 АУДИТАЛСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	743,039,700.00	743,039,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,039,700.00	743,039,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	713,146,600.00	712,898,886.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,200,300.00	326,193,434.00
210101	Үндсэн цалин	224,087,200.00	229,167,818.00
210102	Нэмэгдэл	68,352,700.00	68,745,565.00
210104	Урамшуулал	33,760,400.00	28,280,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтг	38,976,100.00	38,976,000.00
210201	Тэтгэврийн даатгал	25,983,900.00	25,983,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,248,100.00	3,248,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,598,400.00	2,598,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	649,700.00	649,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,496,000.00	6,496,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,023,400.00	136,023,400.00
210301	Гэрэл, цахилгаан	6,169,100.00	6,169,155.00
210302	Түлш, халаалт	122,006,500.00	122,006,500.00
210303	Цэвэр, бохир ус	7,847,800.00	7,847,745.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,653,000.00	5,652,384.00
210401	Бичиг хэрэг	550,000.00	550,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,733,000.00	2,732,994.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	740,000.00	740,000.00
210404	Ном, хэвлэл	580,000.00	579,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	249,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	799,900.00
2105	Нормативт зардал	21,788,400.00	21,787,305.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	224,000.00	224,000.00
210502	Хоол, хүнс	20,064,400.00	20,063,305.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,935,400.00	175,704,837.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	174,435,400.00	174,204,837.00
2107	Томилолт, зочны зардал	710,000.00	702,000.00
210702	Дотоод албан томилолт	710,000.00	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	860,000.00	859,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	860,000.00	859,626.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	6,999,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,499,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,499,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,893,100.00	29,892,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,893,100.00	29,892,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,715,300.00	16,715,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,177,800.00	13,177,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	743,039,700.00	743,039,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,039,700.00	743,039,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	743,039,700.00	743,039,700.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	42	42
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23
620003	Үйлчлэх ажилтан	18	18

